



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

*Хэрлэн сумын 7 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит*

Аудитын код: **ДОА-2021/148/СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Гэрээт аудитор: О.Эрдэнэтуяа

Утас: 7000-3775, khaanconsultingaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар



Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	11
3.4. Материаллаг байдал	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	13
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	14
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	14

1.Хараат бус аудиторын дүгнэлт



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2021.02.24 № 159

танай _____-ны № _____-т

ХЭРЛЭН СУМЫН 7 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
П.НАНСАЛМАА ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 7 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын 7 дугаар цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Хэрлэн сумын 7 дугаар цэцэрлэгийн 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө дүгнэгдээгүй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн Сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

011021235

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	62,559,518.11	63,299,391.11
33	АВЛАГА	-	366,569.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	366,569.00
35	БАРАА МАТЕРИАЛ	62,559,518.11	62,932,822.11
354	Хангамжийн материал	62,559,518.11	62,932,822.11
35420	Аж ахуйн материал	5,422,305.00	5,422,305.00
35470	Бусад хангамжийн материал	57,137,213.11	57,510,517.11
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,422,407,734.90	1,403,940,326.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,422,407,734.90	1,403,940,326.74
392	Биет хөрөнгө	1,296,819,235.02	1,278,575,126.82
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,286,388,013.15	1,286,388,013.15
39202	Хуримтлагдсан элэгдэл	(24,624,787.68)	(49,249,575.36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	15,610,294.00	29,858,794.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,093,407.85)	(7,171,698.53)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	40,857,534.00	40,857,534.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(17,893,410.60)	(23,457,940.44)
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,800,000.00	1,800,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(225,000.00)	(450,000.00)
393	Биет бус хөрөнгө	125,588,499.88	125,365,199.92
39301	Програм хангамж	1,116,500.00	1,116,500.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(528,000.12)	(751,300.08)
39303	Бусад биет бус хөрөнгө	125,000,000.00	125,000,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,484,967,253.01	1,467,239,717.85
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	366,569.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	366,569.00
413	Өглөг	-	366,569.00
4136	Бусад өглөг	-	366,569.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	366,569.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,484,967,253.01	1,466,873,148.85
51	Засгийн газрын хувь оролцоо	1,484,967,253.01	1,466,873,148.85
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	125,000,000.00	125,000,000.00
51101	Өмч - төрийн	125,000,000.00	125,000,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,028,382,553.01	1,010,288,448.85
51210	Өмнөх үеийн үр дүн	1,028,382,553.01	1,028,382,553.01
51220	Тайлант үеийн үр дүн	-	(18,094,104.16)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	331,584,700.00	331,584,700.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,484,967,253.01	1,467,239,717.85

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	332,141,254.86	335,054,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,143,654.86	14,248,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	15,106,174.86	14,248,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15,106,174.86	14,248,500.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	15,106,174.86	14,248,500.00
121	Хөрөнгийн орлого	6,037,480.00	-
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	6,037,480.00	-
13	ГУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	22,039,400.00	17,207,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	288,958,200.00	303,598,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,747,500.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд ома болсон	1,747,500.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,291,900.00	17,207,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,291,900.00	17,207,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	346,326,780.28	353,148,604.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	346,326,780.28	353,148,604.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	344,836,906.51	345,142,282.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	205,775,584.00	240,030,236.16
210101	Үндсэн цалин	182,361,574.00	189,983,576.21
210102	Нэмэгдэл	10,962,738.00	28,740,734.95
210104	Урамшуулал	12,451,272.00	21,305,925.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,664,448.33	30,087,600.00
210201	Тэтгэврийн даатгал	17,432,348.33	19,684,391.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,057,900.00	2,603,515.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,646,400.00	2,069,432.00
210204	Ажилгүйдлийн даатгал	411,600.00	514,993.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,116,200.00	5,215,269.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,100,893.90	15,017,947.57
210301	Гэрэл, шахилгаан	2,668,561.00	1,643,649.96
210302	Тулш, халаалт	8,748,157.00	9,671,336.61
2104	Хангамж, бараа материалын зардал	7,374,670.00	2,867,596.00
210401	Бичиг хэрэг	412,500.00	244,700.00
210402	Тээвэр, шатахуун	250,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	528,250.00	188,300.00
210404	Ном, хэвлэл	110,000.00	150,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150,150.00	113,000.00
210406	Бага үнэтэй, түргэн эзлэгдэх, ахуйн эд зүйлс	456,700.00	336,300.00
210408	Бараа материал акталсны зардал	5,467,070.00	1,334,696.00
2105	Нормативт зардал	53,371,200.00	22,536,815.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,000.00	86,600.00
210502	Хоол, хүнс	53,271,200.00	22,446,015.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	4,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,300,000.00	-
210604	Урсгал засвар	1,300,000.00	-
2107	Томилголт, зочны зардал	118,000.00	-
210702	Дотоод албан томилголт	118,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	470,000.00	807,880.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	290,000.00	567,880.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,662,110.28	33,794,208.16
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,000.00	250,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	163,500.00	828,300.00
210903	Үндсэн хөрөнгийн эзлэгдэл, хорогдол	32,398,610.28	32,715,908.16
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,489,873.77	8,006,321.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	113,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	113,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	989,873.77	7,893,321.27
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	989,873.77	7,893,321.27
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(14,185,525.42)	(18,094,104.16)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(14,185,525.42)	(18,094,104.16)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	310,997,600.00	320,806,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	310,997,600.00	320,806,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	288,958,200.00	303,598,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,747,500.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,747,500.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	20,291,900.00	17,207,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	20,291,900.00	17,207,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	310,997,600.00	320,806,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	310,997,600.00	320,806,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	309,507,726.23	312,799,678.73
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	205,775,584.00	240,030,236.16
210101	Үндсэн цалин	182,361,574.00	189,983,576.21
210102	Нэмэгдэл	10,962,738.00	28,740,734.95
210104	Урамшуулал	12,451,272.00	21,305,925.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,664,448.33	30,087,600.00
210201	Тэтгэврийн даатгал	17,432,348.33	19,684,391.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,057,900.00	2,603,515.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,646,400.00	2,069,432.00
210204	Ажилгүйдлийн даатгал	411,600.00	514,993.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,116,200.00	5,215,269.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,100,893.90	15,017,947.57
210301	Гэрэл, пахилгаан	2,668,561.00	1,643,649.96
210302	Түлш, халаалт	8,748,157.00	9,671,356.61
210303	Цэвэр, бохир ус	6,684,175.90	3,702,941.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,907,600.00	2,190,900.00
210401	Бичиг хэрэг	412,500.00	244,700.00
210402	Тээвэр, шатахуун	250,000.00	500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	528,250.00	188,300.00
210404	Ном, хэвлэл	110,000.00	150,600.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	150,150.00	113,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, акуйн эд зүйлс	456,700.00	994,300.00
2105	Нормативт зардал	54,171,200.00	23,586,815.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	100,000.00	86,600.00
210502	Хоол, хунс	53,271,200.00	22,446,015.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	1,054,200.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,800,000.00	-
210604	Урсгал засвар	2,800,000.00	-
2107	Томиллолт, зочны зардал	118,000.00	-
210702	Дотоод албан томиллолт	118,000.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	470,000.00	807,880.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	290,000.00	567,880.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	500,000.00	1,078,300.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,000.00	250,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дэдлага хийх	400,000.00	828,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,489,873.77	8,006,321.27
2132	Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	113,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	500,000.00	113,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	989,873.77	7,893,321.27
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	989,873.77	7,893,321.27
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-	-
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-	-	-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	125,000,000.00	331,584,700.00	1,028,382,553.01	-	1,484,967,253.01
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	125,000,000.00	331,584,700.00	1,028,382,553.01	-	1,484,967,253.01
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	125,000,000.00	331,584,700.00	1,028,382,553.01	-	1,484,967,253.01
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(18,094,104.16)	-	(18,094,104.16)
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	125,000,000.00	331,584,700.00	1,010,288,448.85	-	1,466,873,148.85

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2.00	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	324,679,100.00	320,806,000.00
21.00	УРСГАЛ ЗАРДАЛ	324,679,100.00	320,806,000.00
210.00	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	324,566,100.00	312,799,678.73
2,101.00	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,700,500.00	240,030,236.16
210,101.00	Үндсэн цалин	189,494,100.00	189,983,576.21
210,102.00	Нэмэгдэл	31,620,900.00	28,740,734.95
210,104.00	Урамшуулал	19,585,500.00	21,305,925.00
2,102.00	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	30,087,600.00	30,087,600.00
210,201.00	Тэтгэврийн даатгал	20,459,600.00	19,684,391.00
210,202.00	Тэтгэмжийн даатгал	2,407,000.00	2,603,515.00
210,203.00	ҮОМШӨ-ний даатгал	1,925,600.00	2,069,432.00
210,204.00	Ажилгүйдлийн даатгал	481,300.00	514,993.00
210,205.00	Эрүүл мэндийн даатгал	4,814,100.00	5,215,269.00
2,103.00	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,057,500.00	15,017,947.57
210,301.00	Гэрэл цахилгаан	1,643,600.00	1,643,649.96
210,302.00	Түлц халаалт	9,671,400.00	9,671,356.61
210,303.00	Цэвэр, бохир ус	3,742,500.00	3,702,941.00
2,104.00	Хангамж, бараа материалын зардал	3,761,400.00	2,190,900.00
210,401.00	Бичиг хэрэг	244,700.00	244,700.00
210,402.00	Тээвэр, шатахуун	500,000.00	500,000.00
210,403.00	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	188,300.00	188,300.00
210,404.00	Ном, хэвлэл	150,600.00	150,600.00
210,405.00	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	613,000.00	113,000.00
210,406.00	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,064,800.00	994,300.00
2,105.00	Нормативт зардал	30,908,400.00	23,586,815.00
210,501.00	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	286,600.00	86,600.00
210,502.00	Хоол хүнс	29,567,600.00	22,446,015.00
210,503.00	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,054,200.00	1,054,200.00
2,106.00	Эд хогшил, урсгал засварын зардал	2,150,000.00	-
210,604.00	Урсгал засвар	2,150,000.00	-
2,108.00	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	822,400.00	807,880.00
210,801.00	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	582,400.00	567,880.00
210,802.00	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00
2,109.00	Бараа үйлчилгээний бусад зардал	1,078,300.00	1,078,300.00
210,901.00	Бараа үйлчилгээний бусад зардал	250,000.00	250,000.00
210,902.00	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	828,300.00	828,300.00
213.00	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	113,000.00	113,000.00
2,132.00	Бусад урсгал шилжүүлэг	113,000.00	113,000.00
213,209.00	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	113,000.00	113,000.00
1,310.00	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	324,679,100.00	320,806,000.00
131,001.00	Улсын төсвөөс санхүүжих	324,679,100.00	320,806,000.00
131,007.00	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	307,471,600.00	303,598,500.00
1,320.00	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	17,207,500.00	17,207,500.00
132,001.00	Орон нутгийн төсвөөс	17,207,500.00	17,207,500.00



2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		00.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		00.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		00.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		00.00
131106	Төсвийн урамшуулал		00.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3. Аудитын тайлан

3.1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 7 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг П.Нансалмаа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 10-наас 2021 оны 02 дугаар сарын 15-ны хооронд Хаан консалтинг аудит ХХК-ийн гэрээт аудитор О.Эрдэнэтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Хэрлэн сумын 7 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 22-ний өдрийн 02 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙ

Хэрлэн сумын 7 дугаар цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хүүхэд бүрийг хүндэтгэн тэдэнд өөрийнхөөрөө байх өөрөө сонгох, бусадтай зохицон харилцах, дотоод ертөнцөө нээх боломж олгож, өөртөө итгэлтэй эрүүл, баяр баясгалантай хүүхдийг төлөвшүүлнэ.
- Хичээл хөгжүүлэх үйл ажиллагааг чанартай бэлтгэн, хүүхдийн онцлогийг харгалзан, адил тэгш оролцоог хангасан байдлаар зохион байгуулах чиглэлээр багшийн ур чадварыг хөгжүүлэх.
- Сургалтын явц үр дүнг бодитой үнэлэн хичээл сургалтын үйл ажиллагааны төлөвлөлтөд тусган чанартай хэрэгжүүлнэ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГО, ДОТООД ХЯНАЛТ

Хэрлэн сумын 7 дугаар цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү, хяналт аудитын алба 2020 онд санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Хэрлэн сумын 7 дугаар цэцэрлэгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 353,148.6 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 7,062.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хэрлэн сумын 7 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17,727.5 мянган төгрөгөөр буюу 1.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага		366.5	366.5
Урьдчилгаа			
Бараа материал	62,559.5	62,932.8	373.3
Үндсэн хөрөнгө	1,422,407.7	1,403,940.4	-18,467.3
Нийт хөрөнгө	1,484,967.2	1,467,239.7	-17,727.5
Өр төлбөр		366.5	366.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,484,967.2	1,466,873.2	-18,094.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,484,967.2	1,467,239.7	-17,727.5

Авлага, өглөгийн дансны 366.5 мянган төгрөг нь хөгжлийн бэрхшээлтэй албан хаагчаас суутгасан хувь хүний орлогын орлогын албан татварын буцаан олголтоос үүссэн.

Бараа материал данс 62,932.8 мянган төгрөг болж 373.3 мянган төгрөгөөр өссөн нь батлагдсан төсвийн хөрөнгөөр худалдан авсан аж ахуйн материалаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө данс 1,403,940.4 мянган төгрөг болж 18,467.3 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн элэгдлээс шалтгаалжээ. Хөрөнгийн элэгдэл 32,715.9 мянган төгрөг байна.

Үндсэн хөрөнгө нь Хэрлэн сумын хөгжлийн сангаас 1,2-р хоолны тогоо 9,000.0 мянган төгрөг, хөрөнгө оруулалтаар 2 ширхэг нөөтбүүк 5,248.5 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө актлаагүй байна.

Засгийн газрын оролцоо данс 1,466,873.2 мянган төгрөг болж, 18,094.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Хэрлэн сумын 7 дугаар цэцэрлэгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 2,913.3 мянган төгрөгөөр буюу 0.9 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 6,821.9 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан гарсан зардал байхгүй байна.

3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 382,465.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 382,465.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 57,786.4 мянган төгрөгөөр бууруулж 324,679.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 324,679.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 307,471.6 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 17,207.5 мянган төгрөгийг орон нутгаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 303,598.5 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 17,207.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, нийт 320,806.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 312,912.7 мянган төгрөгийг зарцуулж 7,893.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 312,799.6 мянган төгрөг буюу 98 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал зардлыг 670.2 мянган төгрөгөөр, бараа материалын зардлыг 1,570.5 мянган төгрөгөөр, хүүхдийн хоолны 5,652.6 мянган төгрөгийг тус тус дутуу зарцуулсан нь Ковид-19 цар тахал гарснаас үүдэн, хөл хорио тогтоон үйл ажиллагаа явуулаагүйтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар гүйлгээ гараагүй байна

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг байршуулсан байна.



3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа зөрчилгүй гарсан байна.

3.9. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 366.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 366.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж баталгаажуулав.

Хөгжлийн бэрхшээлтэй, групптэй ажилтны цалингаас 336.5 мянган төгрөг суутган авсныг авлага, өглөг үүсгэж залруулсан.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар хөгжлийн бэрхшээлтэй, групптэй ажилтны цалингийн орлогоос суутган тооцсон 366.5 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг зөрчин хөгжлийн бэрхшээлтэй 1 ажилтны цалингийн орлогоос нийт 366.5 мянган төгрөгийн татвар суутгасан нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх “дараах орлогыг албан татвараас чөлөөлнө”, 22.1.2 дахь “хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого”, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх “хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, ...” гэсэн заалт, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Байхгүй.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Хэрлэн сумын 7 дугаар цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			ДОА-2021/148/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хэрлэн сумын 7 дугаар цэцэрлэг		Мянган төгрөгөөр



Хэрлэн сумын 7 дугаар цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1 3	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтны цалингийн орлогоос татвар суутган авсан.	366.5	Албан шаардлага өгөх	Эрхлэгч, нягтлан бодогч	П.Нансалмаа Ю.Сувд-Эрдэнэ
ДҮН		366.5			